



ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ХОХИРЛЫГ ЭРХ ЗҮЙН ХУВЬД ҮНЭЛЭХ АСУУДАЛ

LEGAL ASSESSMENT OF PSYCHOLOGICAL HARM EXPERIENCED BY CHILD VICTIMS OF DOMESTIC VIOLENCE

Эрдэнэдаваагийн Сарантуяа ¹

Shihihutug University, E-mail: sarantuya1114@gmail.com

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

Хүүхэд хамгаалал, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл, хохирогч хүүхдийн сэтгэл зүйн нөхөн төлбөр, хохирлыг үнэлэх эрх зүйн зохицуулалт

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2023, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн:
2023, 04 сар

Keywords:

child protection, psychological harm classification, compensation for child victims, legal regulation of harm assessment

Article history:

Received Dec, 2024
Revised Feb, 2025
Accepted Mar, 2025

ХУРААНГУЙ

Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэргүүдэд хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож нөхөн төлбөрийг мөнгөн хэлбэрээр олгож буй эрх зүйн зохицуулалт нь “Гэм буруугийн зарчим”-д суурилсан. Энэхүү зохицуулалт нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, учруулсан сэтгэлзүйн хохирлыг арилгах, нөхөн төлбөрийн хэмжээг зохистойгоор тогтоох зорилготой. Хууль тогтоомжид хүүхдэд учирсан сэтгэлзүйн хохирлын үнэлэмжийг тодорхойлохдоо гэм хорын хариуцлага хүлээх этгээдийг тодорхойлж авч үзсэн байна. Гэвч хүүхдэд учирсан сэтгэлзүйн хохирлыг үнэлэх хэм хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих эрх бүхий байгууллагын чиг үүрэг тодорхой бус байгаа нь хохирогч хүүхдийн хамгаалалт, сэтгэц зан үйлийн аюулгүй байдал, эрх зүйн байдлыг хангахад хүндрэл учруулж байна. Иймд энэхүү өгүүлэлд дээрх зохицуулалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорив.

Abstract: The Special Part of the Criminal Code of Mongolia establishes a legal framework for monetary compensation for victims of certain crimes, based on the classification of psychological harm suffered and the principle of partial fault. This framework aims to protect the rights and legitimate interests of children, ensuring proportionate compensation for psychological harm. However, the lack of clear standards for assessing psychological harm and the ambiguous manates of

¹ Шихихутуг их сургуулийн докторант

responsible authorities impede the effective protection of child victims psychological well being and legal status. This article examines the current regulatory framework and highlights its primary challenges.

Энэ өгүүлэл СС BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1.Танилцуулга

Энэхүү өгүүлэл нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн сэтгэл зүйн хохирлыг эрх зүйн үүднээс үнэлэх асуудлыг судалсан болно. Монгол Улсын Эрүүгийн хууль болон Шүүх шинжилгээний тухай хуульд хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоож, нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэс бүрдсэн хэдий ч уг зохицуулалтын хэрэгжилт, хяналтын тогтолцоо хангалтгүй байгаа нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад хүндрэл учруулж байна.

Судалгаанд гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн сэтгэл зүйн болон зан үйлийн өөрчлөлтийн талаар онолын эх сурвалжуудыг судалж, Монгол Улсын шүүхийн практикт гарсан шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн. Үүний хүрээнд хүүхдийн сэтгэл зүйн хохирлыг тогтоох, нөхөн төлбөр гаргуулах, хохирогчийг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалт болон хэрэгжилтийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлов.

Судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн олон хэрэгт шүүх гэм бурууг тогтоож шийдвэрлэсэн боловч хүүхдийн сэтгэл зүйн хохирлыг үнэлэх, нөхөн төлбөрийг шийдвэрлэх асуудал хангалттай тусгагдаагүй байна. Иймд хүүхдийн сэтгэл санааны хохирлыг бодитой үнэлэх аргачлал, хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг бэхжүүлэх шаардлагатай байна

2. Арга зүй

Арга зүйн хувьд энэхүү судалгаанд Эрүүгийн хуульд заасан 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны нөхөн төлбөрийн хяналтад шинжилгээ хийх, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн сэтгэл зүйн зан үйлийн илрэх сөрөг шинж, хохирогч хүүхдийн нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхийг зорив.

Судалгаанд хууль зүйн аналитик, харьцуулан судлах аргуудыг хослуулан хэрэглэсэн: Үүнд:

-Эрүүгийн хууль болон Шүүх шинжилгээний тухай хуулиуд мөн холбогдох журмуудын эрх зүйн зохицуулалтын бүтэц, агуулгыг харьцуулан судлаж,

- Хүүхдийн сэтгэл зүйн зан үйлийн учруулсан хохирлын аналитик аргаар шүүхийн шийдвэр дүн шинжилгээ хийлээ.

3. Судалгааны үр дүн

Энэхүү өгүүллээр Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11 дүгээр зүйлийн 11.7, 2.1 дэхь хэсэгт зааснаар “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг “хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн” хүүхдэд учруулсан хор хохирлыг үнэлэхтэй холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхийг зорив.

Хүүхдийн эрх, эрх чөлөө, түүний эрх ашгийг, аливаа эрсдлээс хамгаалах нь улс орны тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг юм. Сүүлийн жилүүдэд Монгол улсын хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэгдсэн бодлогын олон арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн боловч хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох, тэр дундаа гэр бүлийн орчинд хүчирхийлэлд өртөх асуудал анхаарал татсан хэвээр байна.

Монгол улсын хэмжээнд Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2025 оны эхний хагас жилд 6278 зөрчил бүртгэгдсэн.² Мөн Боловсролын сургуулийн орчинд 2025 оны 8 сарын байдлаар 169 хүүхэд хохирсон. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн 70 орчим хувь нь гэр бүлийн орчинд, хүүхдийг хамгаалах үүрэг хүлээсэн эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар өөрсдөө гэм буруутай этгээд болж, хүүхдийн сэтгэл зүй, биемахбодод нөхөж баршгүй хохирлыг учруулж байгаа нь сэтгэл санааны зан үйлийн эмгэгийг хамгаалах, хүүхэд хамгааллын нарийвчлалсан механизмыг сайжруулах шаардлага үүсэж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоох байгууллагаас 2016 онд батлагдсанаас өнөөдрийг хүртэлх хугацаанд хүүхэд эрх, хүүхэд хамгааллын эрх зүйн тусдаа зохицуулалтыг бий болгож хүүхэд төвтэй үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн цогц шинэчлэлийг бий болгосон. Гэвч хүүхдийн гэр бүлийн орчинд гадуурхагдах, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэл зүйн хохирлыг бүрэн хэмжээгээр өнөөдрийг хүртэл авч хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт дутмаг байсан. Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 хамтарсан тушаал³, “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ыг хэрэгжүүлж эхэлсэн нь хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, сэтгэлзүйн хохирлыг мөнгөн дүнгээр үнэлж нөхөн төлүүлэх эрх зүйн бодит хэм хэмжээг хэрэгжүүлсэн. Энэхүү журам нь хүүхдэд учруулсан биемахбодын бэртэл, гэмтэлээр хязгаарлагдаж байсан бол хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, хүүхдийн цаашдын ирээдүйд уялдуулан авч үзэх суурь зохицуулалтыг бий болгосон.

² Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, Авлигатай тэмцэх газар 2025 он.

³ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268,

А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760055574281>

Монгол улсын Эрүүгийн хуульд заасан 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн улмаас хүүхэд хохирогч болж, сэтгэлзүйн нөхөн төлбөр гаргуулах асуудлыг тодорхой түвшинд зохицуулж байгаа ч цаашид хүүхэд учирч болох хохирлыг хэрхэн зохицуулах талаар тодорхой хэм хэмжээ авах шаардлагатай байна.

Энэхүү судалгаанд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан сэтгэлзүйн нөхөн төлбөртэй холбоотой заалтуудыг хүүхдэд хамаарах хэсгээр судлан, онолын болон эрх зүйн асуудлыг тодорхойлох, олон улсын гэрээ, судлаачдын өгүүлэл, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхээр зорилоо.

Монгол Улсад хүүхдийн сэтгэл зүйн нөхөн төлбөрийн асуудлын эрх зүйн зохицуулалт

Монгол улс 1990 оноос эхлэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үеэс эхлэн хот суурин газруудад тэнэмэл хүүхдийн тоо нэмэгдэж, хүүхдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бий болгох шаардлага үүссэн.⁴ 1996 оноос эхлэн “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль” шинэчлэн баталж өнөөг хүртэл өөр өөрийн төсөөтэй зохицуулалтууд уламжлагдан ирсэн байна. Харин 2016 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль⁵-ийн хүүхдийг хүчирхийллээс хамгаалах эрхзүйн зохицуулалтыг давхар зохицуулсан ихээхэн онцлог билээ. Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан сэтгэл зүйд учруулсан нөхөн төлбөрийг олгох заалтыг харьцуулан авч үзэх нь ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “...иргэн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ..” гэж заасан. Энэ хуулиар иргэний 16 эрхийг баталгаатай эдлэхээр заасан бөгөөд энэ заалтын хэрэгжүүлэх зорилгоор 2017 оны Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр⁶ “...Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д энэ гэмт хэргийг 2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн...” гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгагдсан.

Эрүүгийн хуулиар “...Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч болсон хүүхдийн эрхийг хамгаалах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, сэтгэл зүйн зан үйлд учруулсан хохирлыг гаргуулах, хүүхдийн эрх ашгийг хангах эрх зүйн шинэлэг зохицуулалтыг бий болсон. Мөн Эрүүгийн хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуулиар “... Хүүхдийн эсрэг гэмт хэрэг...” хохирогч хүүхдэд учруулсан хохирлыг шүүх шинжилгээний дүгнэлт болон холбогдох байгууллагуудын үүрэг оролцоог хангаж, хариуцлагын тогтолцоог зохицуулсан шинэлэг зохицуулалт бий болгосон.

Гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд “Эцэг, эх хүүхдийн хоорондын эрх, үүргийг” мөн тус хуулийн 8 дугаар бүлэгт “хүүхдийн асран хамгаалах, харгалзан дэмжигчийн эрх” үүрэг тусгагдсан.⁶ Энэхүү хуульд заасан үндэслэлээр хүүхдийн эрхийг

⁴ Хүүхэд хамгаалал ба зарим асуудал 2016 он. 47-р тал.

⁵ www.Legalinfo.mn

⁶ Цагдаагийн ерөнхий газар. (2020). Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч гэмт хэргийн криминологийн судалгааны тайлан (2018–2020). Этимологи буюу үгийн гарвал зүйн талаас авч үзвэл: “Гэр бүл” гэдгийг Ц.Дамдинсүрэн,

хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах, сурган хүмүүжүүлэх үүргийг хуулиар нарийвчлан зохицуулсан. Мөн “Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр” нь эрсдэлтэй нөхцөл тулгарч эрсдэлд өртсөн хүүхдэд үзүүлж анхан шатны тусламж үйлчилгээ, нөхөн сэргээх, урьдчилан хамгаалах, сэтгэлзүйн үйлчилгээг хамруулж, сургалтын үйл ажиллагаа, хүний нөөц, тогтолцоо, хамтын ажиллагааг бий болгон хүүхэд эрх, хамгааллыг нөхцлийг илүү өргөн хүрээнд зохицуулсан.

Гэвч Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7, 2.1 дэхь хэсэгт “хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн” гэмт хэрэгт сэтгэл зүйн хохирлыг гаргуулахаар заасан боловч энэхүү зохицуулалтад хяналтын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтгүй орчин үүсэж, хохирогч өөрийн эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын учруулсан хохирлыг нэхэмжлэх, нөхөн төлбөрийг бүрэн зарцуулах эрх зүйн зохицуулалтын хяналт хамгаалалтаас гадуурхагдах хүүхдэд дахин сэтгэл зүйн зан үйлийн хохирлыг үүсгэх нөхцөл байдлыг бий болгож байна.

Хүүхдийн эрхийн хорооны тайлбараас үзэхэд, “хүчирхийлэл” гэдэг ойлголт нь физик, сэтгэл зүйн, бэлгийн хүчирхийлэл, халамжийн болон мөлжлөгийн хамарсан өргөн хүрээтэй ойлголт хэмээн тодорхойлжээ. (Committee on the Rights of the Child, 2011)⁷. Хүүхдийн эрхийн конвенци (CRC) нь хүүхдүүдийг бүх төрлийн хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн тус конвенцид хүүхдийг бүх сэтгэл зүйн хүчирхийлэл, гэмтэл, халамжийн дутагдал, хүчирхийлэл хамгаалахыг тодорхой заасан (CRC, 1989).

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн сэтгэл зүйн болон зан төлөвийн өөрчлөлтийг судлаачдын бүтээлд үндэслэн авч үзвэл:

Сэтгэл зүйн болон зан үйлийн асуудал үүсдэг (Finkelhor, 1994; WHO, 1999)⁸. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд ихэвчлэн PTSD-ийн (Post-Traumatic Stress Disorder, гэмтлийн дараах стрессийн эмгэг)-д өртөх магадлал өндөр байдаг. (McLaughlin & Peverill, 2020; APA, 2022). PTSD -ийн шинж тэмдэг нь нэвтрэх дурсамж, сэтгэл хөдлөлийн сөрөг өөрчлөлт, зарим хүүхдүүд шинж тэмдэг шууд илэрдэггүй, насанд хүрэхэд хожуу илэрэх тохиолдол байдаг. (McLaughlin & Peverill, 2020).⁹ **Шүүх болон хамгаалалтын үнэлгээнд хүүхдийн сэтгэлзүйн байдлыг үнэлэх нь чухал хохирогчийн мэдүүлэг болон нотолгоог бататгахад дэмжлэг үзүүлдэг.** (Arce, 2017).¹⁰ Хүүхдийн нас, хүйс, өмнөх гэмтлийн түүх, хүчирхийллийн төрөл, хохирогч ба үйлдэгчийн харилцаа зэрэг хүчин зүйлс нь сэтгэлзүйн хохирлын түвшинг тодорхойлдог байна. (McLaughlin & Peverill, 2020). Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон

А.Лувсандэндэв нар “айл өрх”, “айл гэр”-г гэж тайлбарласан бол, Я.Цэвэл “Айл” гэдэг нь өрх ам, гэрийн доторх хүмүүс гэж тайлбарлажээ.

⁷Хүүхдийн эрхийн хороо нь Нэгдсэн Үндэсний байгууллага бөгөөд Хүүхдийн эрхийн конвенц (Convention on the Rights of the Child, CRC)-ийг хэрэгжүүлэхэд хяналт тавих үүрэгтэй. Энэ хороо нь 196 оны улс орны үйл ажиллагааг хянаж тайлан гаргуулдаг байна.

⁸ Finkelhor, D. (1994). The international epidemiology of child sexual abuse. *Child Abuse & Neglect*, 18(5), 409–417.

⁹ McLaughlin, K. A., & Peverill, M. (2020). Trauma exposure and PTSD in children: Evidence from longitudinal studies. *Annual Review of Clinical Psychology*, 16, 225–252

¹⁰ Arce, R. (2017). Forensic evaluation of child sexual abuse victims. *Journal of Forensic Psychology*, 32(2), 145–162.

хүүхдийн сэтгэл зүйг урьдчилан хамгаалах нь ирээдүйд бий болох хохирлыг хамгаалах, нийгмийн харилцаанд оролцоход эрүүл аюулгүй байх эрхийг хангах чухал ач холбогдолтой юм.

Шүүхийн шийдвэрийн судалгаа¹¹

Энэхүү хэсэгт Монгол Улсын шүүхийн практик дахь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн 11 дүгээр зүйлийн 11.7-д 2.1 дэхь хэсгийн хууль хэрэглээ, гэм буруугийн зарчмын хэрэгжилт, хүүхдийн сэтгэл зүйн зан үйлд учруулсан хохирлыг шийдвэрлэлтийн холбоо хамаарлыг тодруулахыг зорилоо. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн шүүхийн шийдвэрт дарааллын дагуу судлан авч үзье.

(3.1) Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-ийн 2.1 дэхь хэсэгт заасан “хүүхдийн эсрэг” үйлдсэн гэмт хэрэг нийт 223 шүүхийн шийдвэр байгаагаас, Ахмад настаны эсрэг үйлдсэн 13 шийдвэр, Хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд эсрэг үйлдсэн 2, цагаатгах тогтоох 1 нийт 15 шүүхийн шийдвэрт сэтгэл зүйн нөхөн төлбөртэй холбоотой 1 шийдвэр, үүнээс Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7, 2.1 хэсэгт заасан “Хүүхэд эсрэг үйлдсэн” хүчирхийлэл үйлдсэн нь 63 шийдвэр, нууцлалтай шийдвэр 18 шийдвэр, Гэр бүлийн хүчирхийллийн улмаас биемахбодын хүнд, хөнгөн гэмтэл учруулсан шийдвэрүүдэд, сэтгэл зүйн хохирлыг гаргуулахаар шийдвэрлээгүй 33 шийдвэр, Иргэний журмаар шийдвэрлэхээр хэвээр үлдээсэн 7 шийдвэр байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдийн сэтгэл санааны хохирлыг шийдвэрлээгүй, насанд хүрээгүй хүүхдийг сэтгэл зүйн хохирлыг нэхэмжлээгүй үндэслэлээр шүүхийн шийдвэрт хүүхдийн сэтгэцэд учруулсан гэм хохирлыг тодорхой хэм хэмжээнд нийцүүлэн дараа дараагийн шатанд зөвлөх, хяналт тавих үүргийг шийдвэрт нарийвчлан тусгаагүй хэргийн агуулгыг танилцуулбал. Шүүхийн шийдвэрийг түүвэрлэж, гэр бүлийн хүчирхийлэл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргүүдийг түүвэрлэж, судалгаанд хохирогч хүүхдийн биеэ хамгаалах чадваргүй байдал, архи дан согтуурсан, харгис хэрцгий хандах, хүнд гэмт учруулсан шийдвэрийг 2015-2026 онуудын хэргүүдийг шүүхийн шийдвэрийн сангаас хайлтын тусламжтай илрүүлж, 2017 оны Эрүүгийн хууль болон Шүүхий шинжилгээний тухай хуулиудыг харьцуулан судлаж, шийдвэрт дүн шинжилгээ хийв.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай, эцэг, эх хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн гэмт хэргүүдэд, хүүхдийн эсрэг үйлдсэн шүүхийн шийдвэрт хохирогчийн

¹¹ Энэхүү судалгааны ажилд ашиглагдсан шүүхийн шийдвэрүүд нь 2015 оноос 2026 он хүртэлх анхан шүүхийн шийдвэрүүдийг хамааруулан “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан” <https://shuukh.mn/> сайтыг ашигласан. 2015- 2026 он хүртэлх цахим санд түлхүүр үгийн хайлтын тусламжтайгаар тодорхой хуулийн зүйл, заалт ашиглагдсан шүүхийн шийдвэрийг хайж олоход амар, хялбар байсан ба дээрх шүүхийн шийдвэрүүд нь Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д 2.1 хэсэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүүхэд, сэтгэл санааны хохирол, түлхүүр үгийн тусламжтайгаар олдсон шийдвэрүүд болно.

сэтгэцэд учруулсан хохирлыг нэхэмжлээгүй, нэхэмжлэхгүй болохыг шүүхийн шийдвэрт дурджээ.

Шүүхийн шийдвэр-1. 2017 оны 05 дугаар сарын 03-ны өдөр төрсөн охин насанд хүрээгүй 15 настай Э.О “~~чи яасан том болсон том бэ, чамайг ална шүү~~” гэж хэлэн зодож бие махбодын хөнгөн гэмтэл учруулсан, мөн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай эхнэр болох Х.***, охин Э.О 15 настай Э.*** нарыг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан гэмт хэрэгт холбогджээ.

Эрүүгийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд:¹² Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэн яллаж байгаа хуулийн зүйл, хэсгээр ял шийтгэл оногдуулах үндэслэлтэй байна.” гэж үзжээ.

Хохирогч Х.***, Э., насанд хүрээгүй хохирогч Э.*** нар “гомдол санал, нэхэмжлэх зүйлгүй” гэснийг тус тус дурдсугай гэжээ. Энэ нь хохирогч нь сэтгэл зүйн хохирлын нэхэмжлээгүй тул шийдвэрлээгүй үлдээж шийдвэрлэжээ. ЭХ.11.7-д 2.1 дэхь хэсэг. Хохирогч нь өөрт учруулсан хохирлыг нэхэмжлээгүй, холбогдох материалыг ирүүлээгүй гэх үндэслэлээр нэхэмжлэх зүйлгүй гэжээ.

Шүүхийн шийдвэр-2.¹³ Яллагдагч Д.Б нь 2017 оны 11 дүгээр сарын 03-ны орой Булган аймгийн Бугат сумын 2 дугаар багийн нутагт гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хадам ээж Н.Ц ийг зодож эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол санаатай учруулсан, гэр бүлийн харилцаатай өөрийн эхнэр С.О, хүүхэд Б.У, Б.М нарыг байнга зодсон, харгис хэрцгийн харьцсан, догшин авирлаж тарчлаасан гэмт хэрэгт холбогджээ.

Эрүүгийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол: Шүүгдэгч Д.Б эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.4 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар 8 сарын хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар: Шүүгдэгч Д.Б хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйл, бичиг баримтгүй, бусдад төлөх төлбөргүй, хохирогч С.О, Г.С, Н.Ц нар нэхэмжлэх зүйлгүй гэх үндэслэлээр нэхэмжлэх зүйлгүй гэжээ.

Шүүхийн шийдвэр 1, 2 – оос авч үзвэл. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг 11 дүгээр зүйлийн 11.7-д -2.1 дэхь хэсэгт зааснаар, хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэм буруутай үйлдлийг тогтоон, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, сэтгэл зүйн хохирлыг тогтоон шийдвэрлээгүй нь шүүхийн шийдвэрийн дүгнэлтийг тодорхой хэмжээгээр хүүхдийн эрхийг хязгаарлагдаж, хүүхдүүд цаашид сэтгэл зүйн хохирлын дүгнэлтийг тодорхой тусгаагүй, хүүхэд эрх, хамгааллын хүрээг шүүх хэрхэн тодорхойлж буй талаар таамаглал дээшлүүлэхэд хүндрэлтэй байна. **(Шүүхийн шийдвэр 1,2)**

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эсрэг үйлдсэн шүүхийн шийдвэрт хохирогч сэтгэл санааны хохирлыг нэхэмжлээгүй, иргэний журмаар шийдвэрлэхээр нээлттэй үлдээсэн байна.

¹² Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Шийтгэх тогтоол, дугаар 77. 2017.07.31.

¹³ Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /Эрүүгийн хэрэг/ийн Шийтгэх тогтоол, дугаар 00073. 2018.05.07.

Шүүхийн шийдвэрт¹⁴ -3 Шүүгдэгч Ч.Б нь нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн буюу хамт амьдарч байсан насанд хүрээгүй хохирогч Б.Ог 2020 оны 09 дүгээр сараас хойш 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд байнга зодож гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, насанд хүрээгүй Б.О, Б.Н нарыг асран хамгаалж байхдаа 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Архангай аймгийн Тариат сумын Суман баг тоотод байх гэртээ хэл амаар доромжлон хэрцгий харьцаж, бие махбодын болон сэтгэл санааны шаналал зовиур үүсгэсэн, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Насанд хүрээгүй хохирогч Б.Огийн өгсөн:“...Намайг Ч.Б эгч хичээл хийлгэх гээд зодсон. Миний толгой руу гараараа цохисон, хөлөөрөө миний хөл рүү өшиглөсөн. Тариат суманд эмээ, Ч.Б эгч, Б.Н эгч бид 4 хамт амьдардаг. Ч.Б эгч миний хичээлийг хийлгэх болгондоо толгой руу цохиж зодоод байдаг. Би гомдолтой байна...”

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Д.Б-ийн: миний охиныг зодсон үйлдэлд хуулийн дагуу арга хэмжээ авах байх л гэж бодож байна. Яг тэд хэдэн төгрөг гэж хэлж мэдэхгүй байна...” гэх мэдүүлэг.

Шүүгдэгч Ч.Б нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн үйлдэлд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 2.1 хэсэгт зааснаар, насанд хүрээгүй хүүхэд буюу Б.О, Б.Н нартай удаа дараа хэрцгий харьцаж, бие махбодын, сэтгэл санааны шаналал зовиур үүсгэсэн үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдсэн нь үндэслэлтэй. гэжээ.

Насанд хүрээгүй Б.О, Б.Н нарын хууль ёсны төлөөлөгч Д.Б нь 3.000.000 төгрөгийг нэхэмжилсэн боловч энэ талаар баримт шүүхэд ирүүлээгүй тул хэлэлцэхгүй орхиж, нотлох баримтаа бүрдүүлэн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээж, шүүгдэгчийг энэ тогтоолоор бусдад төлөх төлбөргүй гэж үзжээ.

Шүүхийн шийдвэр 4¹⁵ Я.А, Ч.О нар нь бүлэглэж 2021 оны 10 дугаар сарын 27 ны өдрөөс 28 ны өдрийн хооронд, 2021 оны 11 дүгээр сарын 06, 07, 08-ны өдөр Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 8 дугаар баг аймгийн төвөөс баруун урагш 15 км зайд орших “Энгэрийн худаг” гэх газарт гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох өргөмөл хүү, бага насны хүүхэд А.Б бага насны хүүхэд болохыг мэдсээр байж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн зодож эрүүл мэндэд нь зулайн хуйханд шарх, зүүн чихний сэтэрсэн шарх, баруун хацар, хүзүү, хэвлийд, 2 дал, зүүн шуу, өгзөг, 2 гуянд олон тооны сорви, зүүн шуунд цус хуралт бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт,

Шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.4.1-т зааснаар эрүүл мэндийг түр хугацаагаар сарниулах тул гэмтлийн хөнгөн зэрэгт хамаарна.

¹⁴ Архангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх.

¹⁵ Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, дугаар.2022/ШЦТ/68. 2022.04.12.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол төлбөрийн хувьд хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн зүгээс үрчлэгдсэнээс хойших хүүхдийн мөнгө болон сэтгэл санааны хохирлыг нэхэмжилсэн боловч энэ талаар нотлох баримтаа шүүхэд гаргаж өгөөгүй байна. Иймд хүүхдийн мөнгө болон цаашид гарах хохирогч А.Б сэтгэл засах эмчилгээний зардлын талаарх нотлох баримтаа бүрдүүлэн иргэний журмаар жич нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээж шийдвэрлэв.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1,10.2-т зааснаар насанд хүрээгүй хохирогч А.Б хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, цаашид хүүхдийн эрхийг хангах арга хэмжээ авч ажиллахыг оршин сууж буй нутаг дэвсгэрийн харьяаллаар Сүхбаатар аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт даалгах нь зүйтэй байна.

Шүүхийн шийдвэр 5¹⁶ П.Б нь Төв аймгийн Зуунмод сумын Номт 1 дүгээр баг 34-р байрны 8 тоотод архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох өөрийн төрсөн охин 14 настай, Ө.Ныг байнга буюу 2021 оны 02 дугаар сарын 10-ны орой чи миний хамрыг хугалчихлаа гэх шалтгаанаар орноос чирч газарт буулган толгой хэсэгт 3-4 удаа өшиглөн, нуруун дээр нь хөлөөрөө 5-6 удаа дэвсэж, нүүр хэсэгт нь гараараа 1 удаа алгдсан. Мөн 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдөр архи уулгасангүй гэх шалтгаанаар нуруу хэсэгт нь цохисон. 2021 оны 03 дугаар сарын 28-ны шөнө энэ хэрүүл маргаан чамаас боллоо гэх шалтгаанаар нуруу хэсэгт нь гараараа 3 удаа цохиж зодон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт холбогджээ.

Эрүүгийн анхан шатны шүүхий шийтгэх тогтоол. Шүүгдэгч П.Бгийн Төв аймгийн Зуунмод сумын Номт 1 дүгээр баг 34-р байрны 8 тоотод архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох өөрийн төрсөн охин 14 настай, Ө.Ныг байнга буюу 2021 оны 02 дугаар сарын 10-ны орой чи миний хамрыг хугалчихлаа гэх шалтгаанаар орноос чирч газарт буулган толгой хэсэгт 3-4 удаа өшиглөн, нуруун дээр нь хөлөөрөө 5-6 удаа дэвсэж, нүүр хэсэгт нь гараараа 1 удаа алгдсан. Мөн 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдөр архи уулгасангүй гэх шалтгаанаар нуруу хэсэгт нь цохисон. 2021 оны 03 дугаар сарын 28-ны шөнө энэ хэрүүл маргаан чамаас боллоо гэх шалтгаанаар нуруу хэсэгт нь гараараа 3 удаа цохиж зодон гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн үйл баримт тус тус тогтоогдожээ.

Шүүгдэгч А.П.Бг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн гэм буруутай. Төлөх төлбөргүйг, түүнээс тооцон гаргуулах Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалгүйг тус тус дурдсугай.

Шүүхийн шийдвэрийн 3,4,5-оос авч үзвэл, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн гэм буруутай үйлдлийг тогтоон шийдвэрлэсэн хэдий ч хүүхэд биемахбодын гэмтэл, сэтгэл санааны хохирлыг шийдвэрлэхгүй үлдээж

¹⁶ Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, дугаар 2134000830217, 2021.12.09.

байгаа нь шүүхийн шийдвэр хүрээ, хязгаарлагдмал хүүхдийн хамгаалах эрх зүйн зохицуулалт нь учир дутагдалтай байна. (Шүүхийн шийдвэр 3,4,5)

4. Дүгнэлт

Энэхүү өгүүллээр Эрүүгийн хууль (2017) дахь 11 дүгээр зүйлийн 11.7-д 2.1 хэсэгт зааснаар “Хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн” гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл зүйн хохирлын нөхөн төлбөрийн зохицуулалтыг судлаж, холбогдох бусад хууль тогтоомж болон шүүхийн практиктай харьцуулан шинжиллээ.

Судалгааны дүнгээс үзэхэд, өмнөх эрх зүйн зохицуулалтад хүүхдийн сэтгэл санааны хохирлын асуудал тодорхой тусгагдаагүй байсан бол (2017) Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар уг асуудлыг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн нь хүүхдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалахад чухал ахиц болсон байна.

Энэхүү зохицуулалт хүүхдийн эрх, ашгийг хамгаалж ирээдүйд үүсэж болзошгүй сэтгэл зүйн зан үйлийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, сэтгэл санааны хор хохирлыг тооцоолох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн бөгөөд практикт тодорхой хэмжээнд хэрэгжиж эхэлж байна. Уг зохицуулалтын зорилгын нэг болох хүүхдийн сэтгэл санааны хохирлыг бодитоор тогтоох, хэрэгжүүлэхэд хяналт тавих байгууллагуудын уялдаа холбоо, хариуцлагын асуудлыг нарийвчлан судалж, гэм буруугийн нийцүүлэн гэм буруутай этгээдийн хүлээх хариуцлагыг тодорхойлох нь хүүхдийн эрхийг хангахад чухал ач холбогдолтой юм.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхдэд сэтгэл санааны хор хохирлыг гаргуулах явцад хүүхдийн өөрийн хүсэл, зориг мөнгөн төлбөрийн гаргуулах асуудалд хууль ёсны төлөөлөгчийн нөлөөлөл ихээхэн ажиглагдаж байна. Энэ нь цаашид хүүхдэд сэтгэл зүйн эмгэг, эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамгаалах үүрэг, хариуцлагыг алдагдуулах, улмаар хүүхдийн эрхэд халдсан үйлдэлд хариуцлага тооцох, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлбөрийг бодитоор хэрэгжүүлэх эрх зүйн суурь зохицуулалт хангалттай бэхжээгүй байгааг илтгэж, тодорхой зохицуулалтын хийдэл байгааг харуулж байна.

Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн хүрээнд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гэм буруугийн зарчим болон нөгөө талаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаанд учирсан хор хохирлын нөхөн төлбөрийг шийдвэрлэхгүй орхигдуулах явдал нь гэм буруутай этгээдэд дахин гэмт үйлдэл хийх боломжийг бүрдүүлэх, хохирогчийг хамгаалах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд зөрчил үүсэх нөхцлийг бий болгож байна. “Манай улсын шүүхийн шийдвэрлэлтийг авч үзвэл” Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн” биемахбодын гэмтэл, харгис хэрцгий харьцах, архи дан согтуурсан үедээ хүүхдэд хүнд гэмтэл санаатай учруулсан үйлдлүүдэд” шүүх гэм буруутай этгээдэд гэм бурууг шийдвэрлээд, насанд хүрээгүй хүүхдэд учруулсан хор хохирлыг цаашид хэрхэх талаар дурдаагүй, насанд

хүрээгүй хүүхдэд учруулсан сэтгэл зүйн хохирлыг дүгнэлтийг гаргуулах талаар эрх бүхий байгууллагын дүгнэлтийг оруулахгүй байх, нэхэмжлэхгүй гэдэг үндэслэлийг баримтлан шийдвэрлэлт хийж байгаа нь хуучин хуулийн зохицуулалтад тулгуурлан хүүхдийн эрхийг хамгаалах эрхий бүхий байгууллагуудын үүрэг оролцоог тайлбарлахгүй байх нь өмнөх шүүхийн шийдвэрүүдээс сайжруулалт хийдэгдэхгүй байгаа нь харагдаж байна.

Иймд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй этгээдийн хариуцлагын зохицуулалтыг гэм буруугийн зарчмын хүрээнд авч үзэх нь зүйтэй боловч хохирогчийг дахин хохирогч болохоос урьдчилан сэргийлэх асуудлыг давхар анхаарах шаардлагатай байна. Эрүүгийн хуулийн гэм буруугийн зарчимтай уялдуулан хүчирхийлэл үйлдэгчийн хүлээх хариуцлагыг нарийвчлан тодорхойлохын зэрэгцээ хохирогч хүүхдэд учирсан сэтгэл санааны хор хохирлыг бодитоор тогтоож, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох нь гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах, гэм буруутай этгээдийн хариуцлага цаашид хүүхдэд учрах сэтгэцийн хор хохирлыг нэхэмжлэх нь учир ч болох хүнд эсрдлээс хүүхдийг хамгаалах, хяналтыг бий болгох чухал ач холбогдолтой юм.

5.Эх сурвалж:

- Шихихутуг их сургуулийн докторант
- Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, Авлигатай тэмцэх газар 2025 он.
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760055574281>
- Хүүхэд хамгаалал ба зарим асуудал 2016 он. 47-р тал.
- www.Legalinfo.mn
- Цагдаагийн ерөнхий газар. (2020). Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч гэмт хэргийн криминологийн судалгааны тайлан (2018-2020). Этимологи буюу үгийн гарвал зүйн талаас авч үзвэл: “Гэр бүл” гэдгийг Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нар “айл өрх”, “айл гэр”-г гэж тайлбарласан бол, Я.Цэвэл “Айл” гэдэг нь өрх ам, гэрийн доторх хүмүүс гэж тайлбарлажээ.
- Хүүхдийн эрхийн хороо нь Нэгдсэн Үндэсний байгууллага бөгөөд Хүүхдийн эрхийн конвенц (Convention on the Rights of the Child, CRC)-ийг хэрэгжүүлэхэд хяналт тавих үүрэгтэй. Энэ хороо нь 196 оны улс орны үйл ажиллагааг хянаж тайлан гаргуулдаг байна.
- Finkelhor, D. (1994). The international epidemiology of child sexual abuse. *Child Abuse & Neglect*, 18(5), 409–417.
- McLaughlin, K. A., & Peverill, M. (2020). Trauma exposure and PTSD in children: Evidence from longitudinal studies. *Annual Review of Clinical Psychology*, 16, 225–252
- Arce, R. (2017). Forensic evaluation of child sexual abuse victims. *Journal of Forensic Psychology*, 32(2), 145–162.
- Энэхүү судалгааны ажилд ашиглагдсан шүүхийн шийдвэрүүд нь 2015 оноос 2026 он хүртэлх анхан шүүхийн шийдвэрүүдийг хамааруулан “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан” <https://shuikh.mn/> сайтыг ашигласан. 2015- 2026 он хүртэлх цахим санд түлхүүр үгийн

хайлтын тусламжтайгаар тодорхой хуулийн зүйл, заалт ашиглагдсан шүүхийн шийдвэрийг хайж олоход амар, хялбар байсан ба дээрх шүүхийн шийдвэрүүд нь Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д 2.1 хэсэг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүүхэд, сэтгэл санааны хохирол, түлхүүр үгийн тусламжтайгаар олдсон шийдвэрүүд болно.

- Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Шийтгэх тогтоол, дугаар 77. 2017.07.31.
- Булган аймаг дахь сум дундын анхан шатны шүүх /Эрүүгийн хэрэг/ийн Шийтгэх тогтоол, дугаар 00073. 2018.05.07.
- Архангай аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх,
- Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, дугаар.2022/ШЦТ/68. 2022.04.12.
- Төв аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, дугаар 2134000830217, 2021.12.09.

---oOo---